

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/68/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер:И.Эрдэнэцэцэг Утас: 51-260512 Цахим хаяг: Erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Ш.Наран Утас:51-261628 Цахим хаяг: naransh@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Албан шаардлага.....	17
5.2 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.02 № 06/913
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Удирдлагын академи ТӨҮГ нь захиалгат сургалтад 80.7 сая төгрөг, төслийн санхүүжилтээс 436.4 сая төгрөг, судалгааны ажлын хүрээнд 272.4 сая төгрөг, богино сургалт, гэрээт ажил болон зөвлөх үйлчилгээнд 61.5 сая төгрөгийн нэмэлт ажлын цалингийн зардал тус тус гаргасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант хугацаанд 46.2 сая төгрөгийн танхим түрээс, 107.3 сая төгрөгийн дотуур байр түрээс, 72.6 сая төгрөгийн тогтмол түрээс, нийт 226.1 сая төгрөгийн түрээсийн орлогыг бүрдүүлж 67.8 сая төгрөгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Удирдлагын академи ТӨҮГ-ийн “Төрийн захиргаа”, “Төрийн удирдлага”-ын магистрын сургалтын хөтөлбөрүүдийг Монгол Улсын Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл, Олон улсын магадлан итгэмжлэлийн “ACQUIN” чанарын баталгаажуулалтын байгууллагаар 2032 он хүртэл 6 жилийн хугацаатай олон улсад магадлан итгэмжлүүлсэн байна.

Тайлант хугацаанд нутгийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтын шинжилгээний суурь судалгаа, улсын хил орчмын аймаг, сумын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал, хил хамгаалалтад иргэдийн оролцоо хамтарсан судалгаа, төрийн захиргааны албан хаагчийн сургалтын үр дүнгийн шинжилгээ, эрчим хүчний үнийн шийдвэрт оролцогч талуудын эрх мэдэл, нөлөөллийн шинжилгээ, өрхийн эдийн засагт өндөр насны тэтгэврийн үзүүлж буй нөлөө зэрэг захиалгат судалгааны ажлыг гүйцэтгэж, эрдмийн зөвлөл 87.8 хувиар үнэлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,609,312,609.22	11,320,605,171.39
1.1.4	Бусад авлага	153,177,394.68	695,099,722.78
1.1.6	Бараа материал	333,055,806.60	264,029,071.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	59,590,052.00	52,621,489.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	13,155,135,862.50	12,332,355,454.25
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,031,124,334.63	5,198,914,906.49
1.2.2	Биет бус хөрөнгө	1,984,194,194.30	1,888,331,050.35
1.2.1	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,015,318,528.93	7,087,245,956.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	21,170,454,391.43	19,419,601,411.09
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,220,725,352.37	699,207,005.00
2.1.1.9	Нөөц /БХӨТ төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	108,133,755.50	68,512,187.46
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,328,859,107.87	767,719,192.46
2.1.2.10	Өр төлбөрийн нийт дүн	1,328,859,107.87	767,719,192.46
2.3	2. Эзэмшигчийн өмч		
2.3.1	Төрийн өмч	3,815,844,762.44	3,815,844,762.44
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,461,910,828.64	3,448,701,228.64
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	12,563,839,692.48	11,387,336,227.55
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,841,595,283.56	18,651,882,218.63
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	21,170,454,391.43	19,419,601,411.09

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДД	БАЛАНСЫН ЗҮЙЛ	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,973,521,287.57	9,420,855,812.03
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	12,973,521,287.57	9,420,855,812.03
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	510,880,500.79	1,782,175,081.38
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	1,833,717,719.20	99,375,998.14
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	14,029,977,643.55	10,582,207,714.73
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал /ҮАБЗ/	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,056,456,355.98)	(1,161,351,902.70)
19	Орлогын татварын зардал	-	-
	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	-	-
	Хойшлогдсон татварын зардал /орлого/	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-	-
	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
21	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	(1,056,456,355.98)	(1,161,351,902.70)
	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
	Орлогын нийт дүн	-	-
	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,922,018,782.44	3,461,910,828.64	13,620,050,048.46	21,003,979,659.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(106,174,020.00)	-	246,000.00	(105,928,020.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,815,844,762.44	3,461,910,828.64	13,620,296,048.46	20,898,051,639.54
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлангийн үеийн үр дүн	-	-	(1,056,456,355.98)	(1,056,456,355.98)
8	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,815,844,762.44	3,461,910,828.64	12,563,839,692.48	19,841,595,283.56
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(15,151,562.23)	(15,151,562.23)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,815,844,762.44	3,461,910,828.64	12,548,688,130.25	19,826,443,721.33
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(13,209,600.00)	-	(13,209,600.00)
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Тайлангийн үеийн үр дүн	-	-	(1,161,351,902.70)	(1,161,351,902.70)
14	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	3,815,844,762.44	3,448,701,228.64	11,387,336,227.55	18,651,882,218.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДД	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,182,242,771.69	7,106,709,111.14
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,690,445,963.02	4,227,536,167.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	7,461,392,550.00	2,669,299,232.14
1.1.6	Бусад мөнгөн орлого	30,404,258.67	209,873,712.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,184,518,525.31	9,352,060,575.09
1.2.1	Ажилчдад төлсөн	5,878,048,047.34	4,914,110,162.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	610,354,118.52	715,736,489.28
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	326,608,240.10	302,929,972.88
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	261,829,277.65	320,964,565.77
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	119,053,060.60	142,731,327.82
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	756,333,083.07	539,237,179.39
1.2.9	Бусад мөнгөн зарлага	5,232,292,698.03	2,416,350,877.46
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,002,275,753.62)	(2,245,351,463.95)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	875,755,588.01	1,090,498,385.12
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	875,755,588.01	1,090,498,385.12
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	369,056,909.00	133,854,359.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	369,056,909.00	133,854,359.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	506,698,679.01	956,644,026.12
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(1,495,577,074.61)	(1,288,707,437.83)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,104,889,683.83	12,609,312,609.22
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,609,312,609.22	11,320,605,171.39

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 он		2025 он		Харьцуулалт		
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:	12,973,521.3	9,748,977.1	9,420,855.8	(3,552,665.5)	72.6	(328,121.3)	96.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,218,683.0	3,486,329.7	4,329,888.8	1,111,205.8	134.5	843,559.1	124.2
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	2,081,918.1	3,492,097.0	928,859.9	(1,153,058.2)	44.6	(2,563,237.1)	26.6
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	111,413.9	-	57,033.3	(54,380.6)	51.2	57,033.3	-
Хөрөнгийн орлого	549,538.9	1,090,500.0	1,093,878.4	544,339.5	199.1	3,378.4	100.3
Улсын төсвийн санхүүжилт	7,011,967.4	2,770,550.4	3,011,195.4	(4,000,772.0)	42.9	240,645.0	108.7
Нийт орлого	12,973,521.3	9,748,977.1	9,420,855.8	3,552,665.5	72.6	(328,121.3)	96.6
Нийт зардал	14,029,977.6	9,748,977.1	10,582,207.7	(3,447,769.9)	75.4	833,230.6	108.6
Үүнээс: Удирдлагын зардал	13,820,142.5	9,748,977.1	10,315,018.3	(3,505,124.3)	74.6	556,041.1	105.8
Татварын өмнөх ашиг	(1,056,456.4)	-	(1,161,351.9)	-	-	-	-
Цэвэр ашиг /алдагдал/	(1,056,456.4)	-	(1,161,351.9)	-	-	-	-
Төсвийн төлбөрт нийт дүн	2,099,087.3	1,745,016.9	1,745,016.9	(354,070.3)	83.1	-	-
а/ Орлогын татварт	-	-	-	-	-	-	-
б/ НӨТ	-	-	-	-	-	-	-
в/ НДШ	1,452,950.7	1,289,299.4	1,289,299.4	(163,651.3)	88.7	-	100.0
г/ Хүн амын орлогын татвар	646,005.6	454,982.3	454,982.3	(191,023.3)	70.4	-	100.0
д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	-	-	-	-	-	-	-
з/ Тээврийн хэрэгслийн татвар	131.0	735.2	735.2	604.2	561.1	-	100.0
ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	-	-	-	-	-	-	-
Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	-	-	-	-	-	-	-

Нийт ажиллагсдын тоо	135.0	124.0	124.0	(11.0)	91.9	-	100.0
Нийт цалингийн сан	5,860,772.9	5,609,043.1	5,026,074.3	(834,698.5)	85.8	(582,968.7)	90.0
Нэг ажиллагчийн дундаж цалин	2,505.5	3,350.9	3,350.9	845.5	133.7	-	100.0
Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	-	-	-	-	-	-	-
Хөрөнгө оруулалт				-	-	-	
Нийт авлага	153,177.4	-	695,099.7	541,922.3	453.8	695,099.7	-
Үүнээс: Найдваргүй	-	-	-	-	-	-	-
Нийт өглөг	108,133.8	-	68,512.2	(39,621.6)	63.4	68,512.2	-
Богино хугацаат өр төлбөр	108,133.8	-	-	(108,133.8)	-	-	-
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Удирдлагын академийн дүрмийг Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 366 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 311, 312 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд үйл ажиллагааг явуулна.

Энэхүү дүрэмд “Төрийн албан хаагчдыг мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн албаны хүний нөөцийн менежментийн асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр, төр, захиргааны байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага мөн” гэж үйл ажиллагааг тодорхойлсон байна.

Удирдлагын академийн дүрэмд үйл ажиллагааны чиг үүргийг дараах байдлаар тусгасан байна.

- төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт;
- ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдох төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалт;
- төрийн албанд анх орох иргэнийг төрийн захиргаа, төрийн удирдлагаар мэргэшүүлэх сургалт.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Удирдлагын академи ТӨҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дахь заалт;
- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.2.7 дахь заалт;
- Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн “Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгавар;
- Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар гаргасан байна.

Удирдлагын академи ТӨҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Удирдлагын академи ТӨҮГ-ын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж, ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,750.9 сая төгрөгөөр буюу 8.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	12,609,312.6	11,320,605.2	(1,288,707.4)
Авлага	212,767.4	747,721.2	534,953.8
Бараа материал	333,055.8	264,029.1	(69,026.7)
Үндсэн хөрөнгө	8,015,318.5	7,087,245.9	(928,072.6)
Нийт хөрөнгө	21,170,454.4	19,419,601.4	(1,750,853.0)
Өглөг	1,328,859.1	767,719.2	(561,139.9)
Эздийн өмч	19,841,595.3	18,651,882.2	(1,189,713.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	21,170,454.4	19,419,601.4	(1,750,853.0)

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн хувь оролцоо данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 11,320.6 сая төгрөг болж, өмнөх оны үлдэгдлээс 1,288.7 сая төгрөгөөр буурсан нь төлөвлөсөн орлогын бууралтыг өөрийн эх үүсвэрээс бүрдүүлсэнтэй холбоотой байна.
- Авлагын дансны үлдэгдэл 747.7 сая төгрөг болж, 535.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хадгаламжийн хүүний орлогын хүлээн зөвшөөрөлттэй холбоотой байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 264.0 сая төгрөг болж, 69.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 374.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан, 443.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой.

- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,087.2 сая төгрөг болж, 928.1 сая төгрөгөөр буурсан нь:
 - ✓ Тайлант онд өөрийн хөрөнгөөр 115.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн;
 - ✓ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 341 дүгээр тогтоолоор элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн нийт 674.8 сая төгрөгийн хөрөнгө акталсан;
 - ✓ Тайлант хугацаанд 1,043.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой;
- Өглөг дансны үлдэгдэл 767.7 сая төгрөг болж, 561.1 сая төгрөгөөр буурахад орлогын хүлээн зөвшөөрөлтөөр 521.5 сая төгрөгөөр урьдчилж орсон орлогын бууралт голлон нөлөөлсөн.
- Эздийн өмч дансны үлдэгдэл 18,651.9 сая төгрөг болж, 1,189.7 сая төгрөгөөр буурсан нь:
 - ✓ Тайлант хугацаанд 1,161.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
 - ✓ Үндсэн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлтөд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийн 13.2 сая төгрөгөөр хуримтлагдсан үр дүнг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

Программ хангамжийн талаарх судалгаа авахад 409.3 сая төгрөгийн үнэ бүхий 2020-2025 онд ашиглалтад орсон 11 программыг байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байна. Санхүүгийн программыг хөгжүүлэхтэй холбоотой 2025 онд 4.1 сая төгрөгийн зардал гарсан.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Удирдлагын академи ТӨҮГ-ын захирлын зөвлөл байгууллагынхаа 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд нийт орлогыг 9,749.0 сая төгрөг, нийт зардлыг 9,749.0 сая төгрөгөөр тэнцэж ашиг болон алдагдалгүй ажиллах төлөвлөгөө баталсан байна.

Гүйцэтгэлээр 9,420.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 10,582.2 сая төгрөгийн зардал гарган 1,161.3 сая төгрөгийн татварын дараах алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын төлөвлөгөө 328.1 сая төгрөг буюу 3.3 хувиар тасарч, зардал төлөвлөснөөс нийт дүнгээрээ 833.2 сая төгрөгөөр илүү зарцуулсан.

Тайлант онд 1,161.3 сая төгрөгийн алдагдалтай гарч төлөвлөснөөс 1 дахин их байгаа нь борлуулалтын орлого 328.1 сая төгрөгөөр тасалдсан, төлөвлөлтөд элэгдлийн зардлыг тусгаагүйтэй холбоотой байна.

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- ✓ Байгууллагын орон тооны цомхотгол: Тус байгууллагын батлагдсан орон тоо 133 байхад гүйцэтгэлээр 104 орон тоотой ажиллаж байна. Цалингийн зардлыг 5,609.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,026.1 сая төгрөгийг зарцуулж, 582.9 төгрөгийг дутуу зарцуулсан байна;
- ✓ Удирдлагын академи ТӨҮГ-ын захирлын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/674 дугаар тушаалаар ажилчдын ажлын нэг өдрийн хоолны мөнгийг 10.0 мянган төгрөгөөр, унааны төлбөрийг 1.2 мянган төгрөгөөр баталж, тайлант онд унаа хоолны

хөнгөлөлтийн зардалд 316.8 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 240.5 сая төгрөгийг зарцуулсан;

- ✓ Гадаад томилолт зочид хүлээн авах үйл ажиллагаатай холбоотой 37.9 сая төгрөгийн зардал гаргасан;
- ✗ Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал гараагүй болно.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Удирдлагын академи ТӨҮГ нь тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд 1,400.8 сая төгрөгийн худалдан авалт хийхээр төлөвлөснөөс бараа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн асуудлаар нэр бүхий 3 байгууллагатай 582.9 сая төгрөгийн харьцуулалтын, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авалтын гэрээ байгуулан, өөрийн эх үүсвэрээс уг зардлыг санхүүжүүлэн гэрээний хэрэгжилтийг тухай бүр дүгнэж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд, хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Удирдлагын академи ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн Удирдлагын академи ТӨҮГ-ын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төрийн өмчийн түрээсийн үр ашгийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэлийн аккрузал суурь, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг хүргүүлсэн болно.

Аудитыг “Азуре хүлэг аудит” ХХК-ийн аудитор Д.Мөнхзул гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер П.Болортуяа, гүйцэтгэх захирал Г.Мөнхбаяр, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Удирдлагын академи ТӨҮГ нь 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 20-ны өдөр 01/42 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны жилийн эцсийн орлого, үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 14,029.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 140.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн төслийн саналаар хүргүүлсэн зарим зардлыг татаж баталсан, аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 36 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэхэд дараах зөрчил илэрсэн.

Илрүүлэлт: Тайлант хугацаанд засварын ажил гүйцэтгэх 3 компанитай 53.0 сая төгрөг, хэвлэлийн 4 компанитай 62.9 сая төгрөг, программ хангамжтай холбоотой 3 компанитай 42.4 сая төгрөгийн шууд худалдан авалтын гэрээ тус тус байгуулан худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг тухай бүр нь худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байх зөвлөмж өгсөн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 399.2 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд, 24.2 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлагыг хүргүүлж, 375.0 сая төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Удирдлагын академи нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих 241 мэдээллээс 210 мэдээллийг хугацаанд, 31 мэдээллийг хугацаа хоцроосон, 216.6 сая төгрөгийн 14 мэдээлэл оруулаагүй, хугацаа нь болоогүй 4 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан:", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр:", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан цаглаварт хугацаанд мэдээллийг байршуулаагүй, хугацаа хоцроосон зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Худалдан авалтын харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр 24.2 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" журам, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20 сая төгрөг" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчиж, шууд худалдан авч болох төсөвт өртгийн

хязгаарыг хэтрүүлэн худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Удирдлагын академи ТӨҮГ-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийж илрүүлсэн алдаа зөрчилтэй асуудлын бүртгэл хөтөлж, шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулсан. Завсрын аудитаар 449.5 сая төгрөгийн бараа материал болон урьдчилж төлсөн зардалтай холбоотой алдааны залруулга хийсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 14.1 сая төгрөгийн 3 төлбөрийн актыг барагдуулж, 2,924.7 сая төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлагын дагуу эрх бүхий этгээд арга хэмжээ авч, 1,668.6 сая төгрөгийн 7 албан шаардлагын биелэлтийг хангаж, 143.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	14,145.5	3	14,145.5	100.0
Албан шаардлага	6	444,720.2	6	444,720.2	100.0
Хуулийн байгууллагад шилжүүлэх	1	1,223,938.7	1	1,223,938.7	100.0
Хариуцлага тооцох	2	2,924,722.4	2	2,924,722.4	100.0
Зөвлөмж	3	143,949.5	3	143,949.4	100.0
Нийт дүн	15	4,751,476.2	15	4,751,476.2	100.0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарах шаардлагатай гэж шийдвэрлэлээ. Үүнд:

- Шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн даган мөрдөлт, үйл ажиллагааны онцлогт тохирсон байдлын үнэлэх;
- Авлага цуглуулсан, үлдэгдлийг бууруулах арга хэмжээ авч ажилласан эсэх;
- Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлөөс даалгаж хийлгэсэн судалгааны ажлын зардлын гүйцэтгэлд горим сорил хэрэгжүүлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 49.3 сая төгрөгийн зөрчил² илэрсэнд, 13.1 сая төгрөгийн давтан гаргахгүй байх 2 албан шаардлагыг хүргүүлж, 36.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 49.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тоног төхөөрөмж худалдан авахад 65.0 сая төгрөг төсөвлөсөн бөгөөд уг худалдан авалтыг тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, 52.0 сая төгрөг зарцуулсан байна. Тендерийн үр дүнд 10.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн боловч уг хэмнэсэн төсвийн хөрөнгийг батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нэмэлт тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, хөрөнгө оруулалтын хэмнэлтээр шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Гадаад судалгааны ажилтай холбоотой үүссэн 2.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "заасан эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн өөрийн өмчийн түрээсийн үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Тус байгууллага нь 2023 онд 208м² цайны газрын түрээсийн төлбөрийг 14,425.00 төгрөгөөр тогтоосон гэрээний дүнг зах зээлийн жишиг үнэтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ аваагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11-р зүйлийн 11.2-т "төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах", Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын хавсралт Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журмын 2.16-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээсийн төлбөрийн хэмжээг энэ журмын 11-д заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана"

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах үедээ түрээсийн үнэлгээг зах зээлийн жишиг уялдуулан тогтоож, төрийн өмчийн үр ашгийг дээшлүүлж ажиллах;

2. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой

Илрүүлэлт: Орлого, зардлын хүлээн зөвшөөрөх аккруэл сууриар хүлээн зөвшөөрөөгүйтэй холбоотой өмнөх онд болсон үйл ажиллагаа буюу 100 жилийн ойн арга хэмжээний гэрээний үлдэгдэл төлбөрт 36.2 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу дансны өглөг, төлбөр тооцооны үлдэгдлийг аккруэл суурийн дагуу тухайн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрч бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 65,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалтын тендэр шалгаруулалтаар 52,017.5 мянган төгрөг зарцуулж, үүссэн хэмнэлтээр 10,482.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шууд худалдан авалтын гэрээ байгуулан авсан.	1	10,482.5	-	-	1	10,482.5	-	-	-	-
Гадаад судалгааны авлагын 2,600.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.	1	2,600.0	-	-	1	2,600.0	-	-	-	-
Тус байгууллага нь 2023 онд 208м2 цайны газрын түрээсийн төлбөрийг 14,425 төгрөгөөр тогтоосон гэрээний дүнг зах зээлийн жишиг үнэтэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ аваагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Орлого, зардлын хүлээн зөвшөөрөх аккруэл сууриар хүлээн зөвшөөрөөгүйтэй холбоотой өмнөх онд болсон үйл ажиллагаа буюу 100 жилийн ойн арга хэмжээний гэрээний үлдэгдэл төлбөрт 36,177.4 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсан.	1	36,177.4	-	-	-	-	1	36,177.4	-	-
Дүн	4	49,259.9	-	-	2	13,082.5	2	36,177.4	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд байршуулж ил тод мэдээлэх ёстой 241 мэдээллээс 210-ыг байршуулсан бөгөөд үүнээс 31 нь хугацаа хоцорсон, 31 нь огт мэдээлэгдээгүй, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 20,166,349.3 мянган төгрөгийн 241 гүйлгээг хугацаанд нь мэдээлсэн боловч орлогын 16,834,979.0 мянган төгрөгийн 115 гүйлгээнээс 13 гүйлгээ (164,805.3 мянган төгрөг), мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 440,126.3 мянган төгрөгийн 35 гэрээнээс 51,806.0 мянган төгрөгийн мэдээллийг тус тус байршуулж тайлагнаагүй байна.	1	216,611.3	-	-	-	-	1	216,611.3
Дүн	1	216,611.3					1	216,611.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд засварын ажил гүйцэтгэх 3 компанитай 53,036.0 мянган төгрөг, хэвлэлийн 4 компанитай 62,896.5 мянган төгрөг, программ хангамжтай холбоотой 3 компанитай 42,455.7 мянган төгрөгийн шууд худалдан авалтын гэрээ тус тус байгуулан худалдан авалт хийсэн байна.	1	158,388.2	-	-	-	-	1	158,388.2
Худалдан авалтын харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр 24,200.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн байна.	1	24,200.0	-	-	1	24,200.0	-	-
Дүн	2	182,588.2	-	-	1	24,200.0	1	158,388.2
Нийт дүн	3	399,199.5	-	-	1	24,200.0	2	374,999.5



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1144/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/68/НА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Удирдлагын академийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд тоног төхөөрөмж худалдан авахад 65,000,000.00 (жаран таван сая) төгрөг төсөвлөсөн бөгөөд уг худалдан авалтыг тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж, 52,017,500.00 (тавин хоёр сая арван долоон мянга таван зуун) төгрөг зарцуулсан байна.

Тендерийн үр дүнд 10,482,500.00 (арван сая дөрвөн зуун наян хоёр мянга таван зуу) төгрөгийн хэмнэлт үүссэн боловч уг хэмнэсэн төсвийн хөрөнгийг батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нэмэлт тоног төхөөрөмжийг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж, хөрөнгө оруулалтын хэмнэлтээр шууд худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлагын академийн захирал (Д.Байгал), ерөнхий нягтлан бодогч (А.Даваасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР

9056109
ATA16067
9025061411



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1145/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/68/КА -СТА -ТӨҮГ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Удирдлагын академийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гадаад судалгааны ажилтай холбоотой үүссэн 2,600,000.00 (хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "заасан эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлагын академийн захирал (Д.Байгал), ерөнхий нягтлан бодогч (А.Даваасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Г.МӨНХБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1146/АД150122

Улаанбаатар хот

САГ - 2026/68/НА - СТА - ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Удирдлагын академийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр худалдан авалтын харьцуулалтын арга хэрэглэхгүйгээр 24,200,000.00 (хорин дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийн шууд худалдан авалт хийсэн нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаараас хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12 "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", Монгол улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" журам, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20 сая төгрөг" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зөрчиж, шууд худалдан авч болох төсөвт өртгийн хязгаарыг хэтрүүлэн худалдан авалт хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Удирдлагын академийн захирал (Д.Байгал), ерөнхий нягтлан бодогч (А.Даваасүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЗУРЕ ХҮЛҮГ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Г.МӨНХБАЯР